

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/32/НА-СТА-ТЭЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2026 он

Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Д.Баярсайхан  
Утас:261945 Цахим хаяг: [bayarsaikhand@audit.gov.mn](mailto:bayarsaikhand@audit.gov.mn)  
Аудитын менежер: В.Эрдэнэцогт  
Утас: 261885 Цахим хаяг: [erdenetsogtv@audit.gov.mn](mailto:erdenetsogtv@audit.gov.mn)  
Ахлах аудитор:М.Пагамдулам  
Утас: 261628 Цахим хаяг: [pagamdulamm@audit.gov.mn](mailto:pagamdulamm@audit.gov.mn)  
Аудитор: Ж.Бямбацогт  
Утас: 261628 Цахим хаяг: [byambatsogtj@audit.gov.mn](mailto:byambatsogtj@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	9
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал .....	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	17
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.2 Материаллаг байдал .....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ .....	23

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДАХШҮГ	Дотоод аудит хяналт шинжилгээ үнэлгээний газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30  
Цахим шуудан: info@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД БӨГӨӨД ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Э.БАТШУГАР ТАНАА

2026.04.27 № 1143  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн нэгтгэсэн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу, хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн 442,147.6 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны орлогыг 164,796.6 сая төгрөгөөр дутуу бүрдүүлсэн;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь ажлын байрыг 57.8 сая төгрөгөөр түрээслэн, үр ашиггүй зардал гаргасан;
- Он дамжсан олон жилийн насжилттай 77,589.8 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй, найдваргүй авлага үүсэх эрсдэлтэй хэвээр байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4.1, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## **Асуудлыг онцолсон хэсэг**

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын хэмжээн дэх эрсдэлийг бүртгэх, эрсдэлийн сантай болох зорилгоор газар, хэлтсүүдээс ирүүлсэн эрсдэлийн мэдээлэл болон “Эрсдэлийн менежментийн MNS ISO 31000:2020”, “Эрсдэлийн менежмент-Эрсдэлийн үнэлгээний арга MNS ISO 31010.2016” дугаар бүхий стандартууд, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2023-2026 оны стратеги төлөвлөгөө, Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах засгийн газрын тогтоолуудад тулгуурлан байгууллагын эрсдэлийн удирдлагын стратегийг боловсруулсан байна.

## **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг банканд байршуулж тайлант онд 130.8 сая төгрөгийн хүүгийн өгөөж хүртсэн, мөн Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу торгуулийн орлогоор 3,813.3 сая төгрөг оруулж, сангийн орлогыг нэмэгдүүлсэн байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 03 дугаар тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 792.0 мянган төгрөгөөр тогтоосноор Эрүүл мэндийн даатгалын шимтгэл 15.8 мянган төгрөг болж өссөн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



СМ

С.МАГНАЙСҮРЭН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	365,968,553.8	448,276,219.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	156,246,469.4	217,353,858.2
33	АВЛАГА	168,799,032.1	194,272,761.9
34	УРЬДЧИЛГАА	5,168,556.7	2,450,597.4
35	БАРАА МАТЕРИАЛ	35,754,495.5	34,199,002.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,123,811.8	5,877,210.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,123,811.8	5,877,210.7
39200	Биет хөрөнгө	3,323,944.5	2,971,360.4
39300	Биет бус хөрөнгө	3,799,867.3	2,905,850.2
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>373,092,365.6</b>	<b>454,153,430.3</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	316,851,358.4	198,392,023.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	316,851,358.4	198,392,023.6
41300	Өглөг	316,844,612.4	198,390,906.5
41400	Урьдчилж орсон орлого	6,746.0	1,117.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	56,241,007.2	255,761,406.7
51	Засгийн газрын хувь оролцоо	56,241,007.2	255,761,406.7
51100	Засгийн газрын оруулсан капитал	13,793.9	13,793.9
51200	Хуримтлагдсан үр дүн	56,227,213.3	255,747,612.8
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧ ДҮН</b>	<b>373,092,365.6</b>	<b>454,153,430.3</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,136,473,593.9</b>	<b>2,331,810,208.3</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>358,312,425.0</b>	<b>396,349,784.8</b>
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	358,312,425.0	396,349,784.8
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>75,363,086.8</b>	<b>9,035,758.4</b>
120	Нийтлэг татварын бус орлого	75,363,086.8	9,035,758.4
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,702,798,082.1</b>	<b>1,926,424,665.1</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,148,971,402.1</b>	<b>2,132,289,808.9</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,148,971,402.1</b>	<b>2,132,289,808.9</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>15,702,907.2</b>	<b>14,378,168.0</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,754,763.4	8,880,372.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,094,886.3	1,112,849.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	191,660.2	234,533.2
2104	Хангамж, бараа материалын зардал	334,509.1	257,513.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,057.0	19,320.0
2107	Томилолт, зочны зардал	171,625.0	66,615.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,992,772.7	525,541.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,113,633.5	3,281,422.5

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

212	ТАТААС	137,801,605.0	157,560,143.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,995,466,889.9	1,960,351,497.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(12,497,808.2)	199,520,399.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(12,497,808.2)	199,520,399.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	68,887,934.5	68,887,934.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(149,119.1)	(149,119.1)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	68,738,815.4	68,738,815.4
9	Тайлант үеийн үр дүн	(12,497,808.2)	(12,497,808.2)
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	56,241,007.2	56,241,007.2
11	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	56,241,007.2	56,241,007.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	56,241,007.2	56,241,007.2
19	Тайлант үеийн үр дүн	199,520,399.4	199,520,399.4
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	255,761,406.7	255,761,406.7

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,085,189,124.6	2,307,856,238.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	54,962,730.9	5,185,483.0
120	Нийтлэг татварын бус орлого	54,962,730.9	5,185,483.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,030,226,393.7	2,302,670,755.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,088,928,704.8	2,245,085,821.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,088,928,704.8	2,245,085,821.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	67,819,914.8	11,443,722.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,756,268.4	8,883,716.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,094,886.3	1,112,849.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	191,660.2	235,182.0
2104	Хангамж, бараа материалын зардал	221,944.5	246,945.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,954.6	20,268.9
2107	Томилолт, зочны зардал	173,377.6	72,062.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,058,011.4	554,038.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,276,811.8	318,659.2
212	ТАТААС	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,021,108,790.0	2,233,642,099.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-3,739,580.2	62,770,416.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,071,036.9	1,663,027.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,071,036.9	1,663,027.7
2200	Дотоод эх үүсвэрээр	1,071,036.9	1,663,027.7

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	(1,071,036.9)	(1,663,027.7)
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	(4,810,617.2)	61,107,388.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	161,057,086.6	156,246,469.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>156,246,469.4</b>	<b>217,353,858.2</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Үзүүлэлт		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,164,847,285,900.00</b>	<b>2,238,254,377,089.68</b>	<b>(73,407,091,189.68)</b>	<b>103.4</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,242,447,285,900.00	2,241,620,454,489.68	826,831,410.32	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,989,900,000.00	13,163,068,589.68	826,831,410.32	94.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,989,900,000.00	13,163,068,589.68	826,831,410.32	94.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,989,900,000.00	13,163,068,589.68	826,831,410.32	94.1
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,228,457,385,900.00</b>	<b>2,228,457,385,900.00</b>	-	<b>100.0</b>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,228,457,385,900.00	2,228,457,385,900.00	-	100.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	2,228,457,385,900.00	2,228,457,385,900.00	-	100.0
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>(77,600,000,000.00)</b>	<b>(3,366,077,400.00)</b>	<b>(74,233,922,600.00)</b>	<b>4.3</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	(77,600,000,000.00)	(3,366,077,400.00)	(74,233,922,600.00)	4.3
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,464,319,515,400.00</b>	<b>2,299,523,021,932.00</b>	<b>164,796,493,468.00</b>	<b>93.3</b>
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	-	-
310001	Улсын төсвөөс санхүүжих	-	-	-	-
<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,464,319,515,400.00</b>	<b>2,299,523,021,932.00</b>	<b>164,796,493,468.00</b>	<b>93.3</b>
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	<b>2,464,319,515,400.00</b>	<b>2,295,140,614,514.00</b>	<b>169,178,900,886.00</b>	<b>93.1</b>
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	-	-	-
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,382,407,418.00	-	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	146,271,502,665.96	-	100.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	<b>207,522,711,380.78</b>	-	<b>100.0</b>

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>3</b>	<b>3</b>	<b>-</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	3	3	-	100.0
610002	Төсвөөс гадуур байгууллага	-	-	-	-
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>270</b>	<b>195</b>	<b>75</b>	<b>72.2</b>
620001	Удирдах ажилтан	39	28	11	71.8
620002	Гүйцэтгэх ажилтан	216	152	64	70.4
620003	Үйлчлэх ажилтан	15	15	-	100.0
620004	Гэрээт ажилтан	-	-	-	-

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,967,134.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,967,134.9
122	Тусламжийн орлого	4,967,134.9
1221	Хандив тусламж /дотоод/	4,967,134.9
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,967,134.9
350012	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	4,593,004.2
350013	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	374,130.7
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,110,954.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,110,954.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	437,585.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	188,799.8
210101	Үндсэн цалин	18,926.0
210102	Нэмэгдэл	169,873.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,057.2
210202	Тэтгэмжийн даатгал	24,057.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	224,728.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	88,144.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	136,583.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,673,369.7
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,593,004.2
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	4,593,004.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	80,365.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	80,365.5
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-143,819.9
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	143,819.9
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	143,819.9
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	374,966.8
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	231,146.8

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангийн эрхэм зорилго нь “Монгол хүн бүрийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, даатгалын тогтвортой санг бүрдүүлэн даатгуулагчийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг худалдан авдаг үйлчлүүлэгч төвтэй, нийгмийн хариуцлага бүхий менежментийг хэрэгжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Эрүүл мэндийн даатгалын сан дараах тэргүүлэх чиг үүргийг гүйцэтгэж байна. Үүнд:

- Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлэх;
- Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлогыг нэмэгдүүлж, үзүүлэх тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, хүрээг өргөтгөх;
- Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчлах;
- Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана гэсэн байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Эрүүл мэндийн даатгалын сан нь Монгол Улсын үндсэн хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн эрүүл мэндийн салбарын бодлогыг зохицуулах, хэрэгжүүлэх үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” ЭМДҮЗ-ийн 2025 оны 3 дугаар тогтоол;
- “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” ЭМДҮЗ-ийн 2025 оны 4 дүгээр тогтоол;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” шинэчлэн баталсан;

Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үзлээ.

Тус ерөнхийлөн захирагчийн салбарын дотоод аудит хяналт, шинжилгээ үнэлгээний газар нь тайлант онд дотоод аудитын чиглэлээр 9 арга хэмжээнд хяналт шалгалт хийх удирдамжийг батлуулж, төлөвлөгөөт 7, төлөвлөгөөт бус 2, нийт 9 арга хэмжээнд дотоод аудитыг хийж гүйцэтгэн Санхүү бүртгэлийн хэлтэс, Мэдээлэл технологийн хэлтэс, Бодлого төлөвлөлтийн газар, нэхэмжлэлийн хяналтын хэлтэс, орон нутаг дахь ЭМД-ийн хэлтсүүдэд 26 зөвлөмж өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны А/99 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 81,061.1 сая төгрөгөөр буюу 21.7 хувиар өссөн байна.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 217,353.9 сая төгрөг болж, өмнөх оноос 61,107.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	101,516.7	179,219.3	77,702.6
Арилжааны банк дахь харилцах	54,729.8	38,134.5	(16,595.3)
<b>Дүн</b>	<b>156,246.5</b>	<b>217,353.9</b>	<b>61,107.4</b>

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Нийт мөнгөн хөрөнгийн 82.5 хувь буюу 179,219.3 сая төгрөгийг төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл эзэлж байна. Үүнд: ЭМДС-ийн үлдэгдэл 169,388.2 сая төгрөг, эрсдэлийн сангийн үлдэгдэл 9,600.0 сая төгрөг, ЭМДЕГ-ын нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 231.1 сая төгрөг байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 38,134.5 сая төгрөг нь арилжааны 7 банканд байршиж байгаагаас 70.4 хувь буюу 26,828.6 сая төгрөгийг Чингис хаан банкны үлдэгдэл эзэлж байна. Тус банкны оны эхний үлдэгдэл 30,575.7 сая төгрөгөөс тайлант онд 3,747.1 сая төгрөг төлөгдөж, жилийн эцэст 26,828.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

#### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 194,272.8 сая төгрөг болж, өмнөх оноос 25,473.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.3		(0.3)
Байгууллагаас авах авлага	168,798.7	194,272.8	25,474.0
<b>Дүн</b>	<b>168,799.0</b>	<b>194,272.8</b>	<b>25,473.7</b>

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Авлагын үлдэгдлийн 60.3 хувь буюу 117,049.0 сая төгрөгийг НДЕГ-аас авах ЭМД-ын шимтгэлийн авлага эзэлж байгаа бөгөөд өмнө оны үлдэгдлээс 27,259.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэлд 4-өөс дээш жилийн насжилттай 4 байгууллагын 78,993.1 сая төгрөгийн үлдэгдлээс Капитал банкны авлага 1,800.0 сая төгрөг барагдаж, 77,193.1 сая

төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Капитал банкнаас авах 74,200.0 сая төгрөг, Үндэсний хөрөнгө оруулалтын банкны авлагын үлдэгдэл 2,113.5 сая төгрөг, Хаппи веритас ХХК-ийн Интерферон альфа эмнэлгээс авах авлага 876.8 сая төгрөг, Гараг эгшиг ХХК-аас 2.9 сая төгрөгийн он дамжсан авлагын үлдэгдэлтэй байна.

### 3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 2,450.6 сая төгрөг болж, өмнөх оноос 2,718.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	5,168.6	2,450.6	(2,718.0)
<b>Дүн</b>	<b>5,168.6</b>	<b>2,450.6</b>	<b>(2,718.0)</b>

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэлд улсын болон хувийн эмнэлэг, рашаан сувилал, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд олгосон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн урьдчилгаа төлбөр бүртгэлтэй байна. Үүнд:

Улсын эмнэлэг 1,430.5 сая төгрөг, хувийн хэвшлийн эмнэлэг 248.8 сая төгрөг, рашаан сувилал 57.0 сая төгрөг, эмийн сан 464.2 сая төгрөг, ЭЭМТ болон бусад эмнэлэгт 250.1 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн үлдэгдэлтэй байна.

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 34,199.0 сая төгрөг болж, өмнөх оноос 1,555.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
Бэлэн бүтээгдэхүүн	35,535.60	33,969.5	(1,566.1)
Бичиг хэргийн материал	38.7	41.6	2.9
Аж ахуйн материал	45.6	43.5	(2.1)
Сэлбэг хэрэгсэл	21.4	21.4	(0.0)
Түлш, шатах тослох материал	4.5	0.7	(3.8)
Бусад хангамжийн материал	108.8	122.4	13.6
<b>Дүн</b>	<b>35,754.5</b>	<b>34,199.0</b>	<b>(1,555.5)</b>

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Капитал банкны эрх хүлээн авагчаас өрөнд авсан 1,566.1 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулсан нь бараа материал дансны үлдэгдэл буурахад нөлөөлсөн байна.

Бараа материал дансны үлдэгдлийн 33,966.5 сая төгрөг буюу 99.3 хувийг Капитал банкны эрх хүлээн авагчаас хүлээн авсан хөрөнгө эзэлж байна.

### 3.4.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 5,877.2 сая төгрөг болж, өмнөх оноос 1,246.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
----------	----------------	-----------------	--------------------------

**Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Барилга байгууламж, орон сууц	2,114.8	2,061.9	(52.9)
Тээврийн хэрэгсэл	193.5	184.7	(8.8)
Машин тоног төхөөрөмж	825.2	568.3	(256.9)
Тавилга эд хогшил	190.5	155.4	(35.1)
Бусад үндсэн хөрөнгө	-	1.1	1.1
Программ хангамж	3,200.6	2,306.6	(894.0)
Бусад биет бус хөрөнгө	599.3	599.3	(0.0)
<b>Дүн</b>	<b>7,123.8</b>	<b>5,877.2</b>	<b>(1,246.6)</b>

*Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,663.0 сая төгрөг, хандиваар хүлээн авсан 40.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, акталсан 39.3 сая төгрөг, дахин үнэлгээтэй хөрөнгө хасагдсан 51.3 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Тайлант онд хөрөнгөнд 2,950.3 сая төгрөгөөр элэгдэл байгуулсан байна.

### 3.4.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 198,392.0 сая төгрөг болж, өмнөх оноос 118,459.4 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл*

*/ сая төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН</b>	316,851.4	198,392.0	(118,459.4)
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	316,838.6	198,390.9	(118,447.7)
Байгууллагад төлөх өглөг	1.4		(1.4)
Хувь хүмүүст төлөх өглөг	4.7		(4.7)
<b>Урьдчилж орсон орлого</b>	6.7	1.1	(5.6)
<b>НИЙТ ДҮН</b>	<b>316,851.4</b>	<b>198,392.0</b>	<b>(118,459.4)</b>

*Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд ЭМДС нь гэрээ байгуулахдаа худалдан авах эмнэлгийн тусламж үйлчилгээний хэмжээнд хязгаар тогтоосон, 2025 оны 10 сараас хувийн хэвшлийн эмнэлэгтэй байгуулсан гэрээг цуцалсантай холбоотой өглөг нэхэмжлэлийн тоо 16.9 сая, нэхэмжилсэн дүн 1,796,588.6 сая төгрөгт хүрч 34,572.6 сая төгрөгөөр буурсан байна.

Эрүүл мэндийн даатгалын орлого өмнөх оноос 195,336.6 сая төгрөгөөр өссөн нь өглөгийг 118,459.4 сая төгрөгөөр буурахад гол нөлөө үзүүлсэн байна.

Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөгийн үлдэгдэлд улсын эмнэлэгт өгөх өглөг 118,276.9 сая төгрөг, хувийн хэвшлийн эмнэлэгт 21,260.3 сая төгрөг, рашаан сувилалд 150.7 сая төгрөг, эмийн санд 26,430.6 сая төгрөг, ӨЭМТ-д 1,912.1 сая төгрөг, СЭМТ-д 30,352.2 сая төгрөг, бусад байгууллагад өгөх 8.1 сая төгрөгийн өглөг байна.

### 3.4.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 255,761.4 сая төгрөг болж, өмнөх оноос 199,520.4 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо*

*/ сая төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	13.8	13.8	-
Хуримтлагдсан үр дүн	56,227.2	255,747.6	199,520.4

<b>Дүн</b>	<b>56,241.0</b>	<b>255,761.4</b>	<b>199,520.4</b>
------------	-----------------	------------------	------------------

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 199,520.4 сая төгрөгөөр өсөхөд тайлант үеийн үр дүн голлон нөлөөлсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд эрүүл мэндийн даатгалын санд ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлогыг 945,070.2 сая төгрөг, төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгох санхүүжилтийг 1,119,492.5 сая төгрөг, төрөөс ЭМДШ-ийг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэлийг 706,073.4 сая төгрөг, ажил олгогч болон бусад даатгуулагчийн шимтгэлийн орлогыг 1,044,703.3 сая, бусад орлогыг 11,429.9 сая төгрөг, нийт орлогыг 2,881,699.1 сая төгрөг, нийт зарлагыг 2,787,280.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслөлд өгсөн саналаас нийт орлогыг 356,123.3 сая төгрөгөөр бууруулж 2,525,575.8 сая төгрөгөөр, зардлыг 493,385.1 сая төгрөгөөр бууруулж 2,293,894.9 сая төгрөгөөр анх баталсан байна.

Төсвийн тодотголоор нийт орлогыг 61,256.2 сая төгрөгөөр бууруулж 2,464,319.5 сая төгрөгөөр, зардлыг 51,447.6 сая төгрөгөөр бууруулж 2,242,447.3 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

##### ЭМДС-ийн орлого бүрдүүлэлт:

Тайлант онд эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2,299,523.0 сая төгрөгт хүрч 93.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 11. ЭМДС-ын орлогын төлөвлөгөө гүйцэтгэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
Ажил ологч, даатгуулагчийн шимтгэлээс	1,140,709.0	977,214.9	163,494.1	85.7
Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс	352,203.1	352,203.1	0.0	100.0
Бусад даатгуулагчийн шимтгэлээс	49,831.5	44,146.7	5,684.8	88.6
Төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс	921,575.9	921,575.9	0.0	100.0
Бусад орлого		4,382.4	4,382.4	100.0
<b>Дүн</b>	<b>2,464,319.5</b>	<b>2,299,523.0</b>	<b>169,178.9</b>	<b>93.3</b>

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийгмийн даатгалын ерөнхий газраас ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлогын төвлөрүүлэлт баталсан төлөвлөгөөнөөс 163,494.1 сая төгрөгөөр, бусад даатгуулагчийн шимтгэлийн орлого 5,684.8 сая төгрөгөөр тус тус дутуу төвлөрүүлсэн байна.

Арилжааны банканд байршуулсан мөнгөн хөрөнгөнд бодогдсон хүүгийн орлого 130.8 сая төгрөг, түрээсийн орлого 430.5 сая төгрөг, торгууль, хохирлын нөхөн төлбөр 3,821.1 сая төгрөг, нийт 4,382.4 сая төгрөгийн эх үүсвэрийг бусад орлогоос бүрдүүлсэн байна.

##### Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зарцуулалт

### ЭМДС-ийн зарлага:

Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт зарлагыг 2,242,447.3 сая төгрөгөөр батлаж, гүйцэтгэлээр 2,241,620.5 сая төгрөг буюу 99.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн гүйцэтгэлээр эрүүл мэндийн байгууллагуудад олгох тусламж үйлчилгээний санхүүжилтэд 2,057,370.8 сая төгрөг, эмийн үнийн хөнгөлөлтөд 171,086.6 сая төгрөг, үйл ажиллагааны урсгал зардалд 13,163.1 сая төгрөг, нийт 2,241,620.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 12. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
71605 Эрүүл мэндийн даатгал	2,242,447.3	2,241,620.5	826.8	99.9
80302 Нэг иргэнд ногдох нормативаар	392,839.2	392,839.2	-	100.0
80512 ЭМДСангаас олгох санхүүжилт	1,400,369.5	1,400,369.5	-	100.0
80527 Хувийн эмнэлгүүдэд олгох ТҮ санхүүжилт	89,346.7	89,346.7	-	100.0
81629 Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	89,132.3	89,132.3	-	100.0
81633 Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг	30,973.1	30,973.1	-	100.0
81637 Гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ	54,710.0	54,710.0	-	100.0
81638 Хөнгөлөлттэй эмийн зардал	171,086.6	171,086.6	-	100.0
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	13,989.9	13,163.1	826.8	94.1

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.4.3 Худалдан авах ажиллагаа

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны бараа, ажил үйлчилгээний худалдан авах төлөвлөгөөнд 3,082.2 сая төгрөгийн баталсан төсөвт өртөг бүхий тайлант онд 3,082.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй, 9 төсөл, арга хэмжээ батлагдсан байна. Үүнд бичиг хэргийн материал 89.8 сая төгрөг, бага үнэтэй болон цэвэрлэгээний материал худалдан авах 79.1 сая төгрөг, ӨЭМТ-н гүйцэтгэлийн үнэлгээний журам, үзүүлэлтүүдэд сүрьеэгийн үзүүлэлтүүдийг тусгах замаар анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх сайжруулах зөвлөхийг үйлчилгээ 59.4 сая төгрөг, бусад худалдан авалтыг шууд аргаар худалдан авахаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 2 бараа, 1 үйлчилгээг tender.gov.mn цахим хуудаст зарласнаас нийт 228.3 сая төгрөгийн гэрээ хийгдсэн байна.

#### Аудитын илрүүлэлт:

- ЭМДҮЗ нь ажлын байр түрээслэхдээ 57.7 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

### 3.4.4 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэндийн салбарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 1 хөтөлбөрийн 1 хүрэх үр дүнд 2 шалгуур үзүүлэлтийг баталжээ.

*Хүснэгт 12. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт*

№	Хөтөлбөр	Шалгуур үзүүлэлт	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	2025 онд хүрсэн түвшин	Аудитын дүн	
<b>71605 Эрүүл мэндийн даатгал</b>								
32.4	32.4.1	Эрүүл мэндийн үйлчилгээнд даатгалын, улсын төсвийн болон хувь хүний санхүүжилтийн зохистой харьцааг бий болгож, хүн амын эрүүл амьдралын хэвшлийг төлөвшүүлнэ	Эрүүл мэндийн даатгалын сангийн хамрагдалт /хүйсээр/	2023	92.5	94.0	93.7	93.7
			Эрүүл мэндийн нийт зардалд Эрүүл мэндийн даатгалын сангийн эзлэх хувь	2023	36.0	37.0	83.4	63.2

Эрүүл мэндийн даатгалын сангаас урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээнд 3,504.7 мянган хүнийг хамруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 3,283.5 мянган хүн хамрагдаж, төлөвлөгөө 93.7 хувийн биелэлттэй байна. Мөн эрүүл мэндийн салбарын нийт зардлын 63.2 хувийг ЭМДС-ийн зардал эзэлж байна.

### **3.4.5 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд ЭМДС-ийн нэмэлт санхүүжилтийн дансанд МУЗГ, Азийн хөгжлийн банкттай хамтран хэрэгжүүлж буй “Ковид-19-ийн эсрэг вакцинжуулалтын арга хэмжээг дэмжих төсөл”-ийн хүрээнд 4,593.0 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Үүнээс ӨЭМТ-д 3,611.0 сая төгрөг, СЭМТ-д 982.0 сая төгрөг, нийт 103,932.9 сая төгрөгийн анхан шатны тусламж үйлчилгээний санхүүжилтийг тус тус олгосон байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **Ерөнхий чиглэлийн дагуу авсан нэгдсэн судалгааны үр дүн**

#### Байгууллагуудын орон тооны цомхотголын судалгааны үр дүнгийн талаар:

ЭМДҮЗ-ийн 2025 оны 01 дугаар тогтоолоор ЭМДЕГ-ын орон тоог 285, цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 10,704.0 сая төгрөг, ЭМДҮЗ-ийн орон тоог 11, цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 495.1 сая төгрөгөөр баталсан байна. Засгийн газрын бүтэц, орон тоог 9 хувиар бууруулах чиглэлийн хүрээнд гүйцэтгэх албан тушаалтны 26 орон тоог цомхотгосон байна.

#### Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын судалгааны үр дүнгийн талаар:

Ажлын нэг өдрийн хоол, унааны зардлыг ЭМДЕГ 30.0 мянган төгрөгөөр, ЭМДҮЗ 29.0 мянган төгрөгөөр тус тус тогтоож, тайлант хугацаанд хоол, унааны зардалд ЭМДЕГ 639.7 сая төгрөг, ЭМДҮЗ 40.4 сая төгрөг, нийт 680.1 сая төгрөг баталж, гүйцэтгэлээр 1,060.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

#### Сургалт семинар хурал зөвлөгөөний судалгааны үр дүнгийн талаар:

Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/388 дугаар тушаалаар Эрүүл мэндийн даатгалын санд үүсэж буй нөхцөл байдлыг арилгах, дахин хүндрэл үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулахад 97.7 сая төгрөг зарцуулсан байна.

Программ хангамжийн талаарх судалгааны үр дүн:

ЭМДҮЗ-ийн санхүүгийн тайланд санхүүгийн Acolous программ 3.2 сая төгрөг, бичиг хэргийн программ 3.5 сая төгрөгийн үнэлгээтэй бүртгэлтэй байна. Тайланд онд программын лицензтэй холбоотой 1.0 сая төгрөгийн зардал гарсан байна. ЭМДЕГ-ийн санхүүгийн тайланд 10,027.5 сая төгрөгийн 12 программ бүртгэлтэй байна. Тайланд онд 1,638.0 сая төгрөгийн программын лицензийн зардал гарсан байна.

Гадаад томилолтын, арга хэмжээ, төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн судалгааны зардал гараагүй.

Хороо зөвлөл, ажлын албадын зардлын талаар авсан судалгааны үр дүн

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны 2025 оны нийт зардлыг 824.3 сая төгрөгөөр баталсан байна. Гүйцэтгэлээр цалин, НДШ-ийн зардалд 479.0 сая төгрөг, байр ашиглалтын зардалд 59.7 сая төгрөг, бичиг хэрэг хангамжийн зардалд 28.8 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 235.6 сая төгрөг, нийт 803.1 сая төгрөг зарцуулсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд тус төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн хөрөнгийн бүртгэл, дотоод хяналтыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор М.Пагамдулам, аудитор Ж.Бямбацогт нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер В.Эрдэнэцогт, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 01/626 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 2,331,810.0 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 11,659.0 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын явцад материаллаг байдлыг дахин хянаж, төлөвлөлтийн үеийн материаллаг байдлын түвшнийг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 6.9 сая төгрөгийн зөрчил илэрсэнд төсвийн шууд захирагчид зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

ЭМДЕГ шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 53.5 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлсэн.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийцлийн асуудлаар нийт 57.8 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

**Илрүүлэлт 1:**

ЭМДЕГ нь өөрийн ажлын байртай бөгөөд талбай ашиглалтын хувьд хангалттай байхад ЭМДҮЗ-ийн ажлын алба нь 10 орон тоотой боловч Ворлднэт ХХК-ийн “Юнион Бюлдинг” барилгад ажлын байр түрээсэлж 57.8 сая төгрөгийн зардал гаргаж, өөрийн байгууллагын нөөц бололцоог ашиглахгүй, үр ашиггүй зардал гаргаж байна.

Энэ нь өсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “үр ашигтай байх”, 4.1.9-д “хариуцлагатай байх” гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

ЭМДЕГ нь өөрийн ажлын байрны нөөц боломжийг ашиглах, ЭМДҮЗ байр түрээслэж, төсвийг үрэлгэн зарцуулсан зөрчлийг давтан гаргахгүй байх.

**Илрүүлэлт 2:**

Тус сангийн сайн дурын даатгуулагчийн тоо 25026 хүнээр буурч, орлогын төлөвлөгөө 5,684.8 сая төгрөгөөр тасарсан байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 "төсвийн тогтвортой байдлыг хангасан байх", 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх" гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Сайн дурын даатгалд даатгуулагчийн тоог нэмэгдүүлж, сангийн орлогын нэмэгдүүлэх талаар судалж, арга хэмжээ авах.

**Илрүүлэлт 3:**

ЭМДС-ийн нийт орлогын 55.3 хувийг төрөөс шимтгэлийг нь хариуцан төлдөг иргэдийн шимтгэлийн орлого, төр хариуцах тусламж, үйлчилгээний орлого бүрдүүлж байгаа хэдий ч, сангийн нийт зардлын 88.2 хувийг улсын төсвөөс хариуцах иргэдэд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, мөн хуулийн 6.2.2 “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”, Тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6 "төсвийн хөрөнгийн хуваарилалт, байршуулалт, хэрэглээ нь эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой байх" гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зардлагын тэнцвэртэй байдлыг хангах талаар судлагаа хийж, санхүүгийн оновчтой удирлагыг хэрэгжүүлэх.

**Илрүүлэлт 4:**

2024 оны нэгдсэн төсвийн гүйцэгэлийн тайлангаар Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын эх үүсвэртэй уялдуулж, даатгалын сангаас санхүүжих эмнэлгийн тусламж үйлчилгээний төрөлд дүн шинжилгээ хийж, оновчтой болгох, 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар Эрүүл мэндийн даатгалын санд үүссэн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, Эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд бодлогын шинэчлэл хийх гэсэн зөвлөмжүүдийг өгч байсан боловч хэрэгжилт хангалтгүй өнөөгийн байдалд хүрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 4.2.2 “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 14.2.3 “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.5 “өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах”, 14.2.11 “төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг САГ-2026/32/НА-СТА-ТЕЗ

үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах”, 14.3 “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна” гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж, Эрүүл мэндийн даатгалын санг өрийн дарамтнаас гарах нөхцөл боломжийг судлаж, системтэйгээр даатгалын тогтолцоонд бодлогын шинэчлэл хийх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд харьяа газруудын санхүүгийн тайлангийн аудитаар хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн зарим заалттай, бусад нийцлийн асуудал холбогдох хуулийн зарим заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитаар Эрүүл мэндийн даатгалын сангийн 2 байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, бараа материал, бусад эргэлтийн хөрөнгө, мөнгөн хөрөнгийн данстын хувьд горим, сорил хэрэгжүүлж аудитаар илэрсэн алдаа зөрчлийг жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэж, төсвийн шууд захирагчид асуудлын бүртгэлээр танилцуулж, жилийн эцэст дахин хянаж шийдвэрлэсэн болно.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн:**

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид 118.5 сая төгрөгийн зөрчил арилгах 1 албан шаардлага, 76,758.7 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгч, шийдвэрлэснээс хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 13. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

№	Үзүүлэлт	Илрүүлэлт		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Төлбөрийн акт	-	-	-	-	-
2	Албан шаардлага	1	118.5	1	118.5	100.0
3	Хариуцлага тооцох албан шаардлага	-	-	-	-	-
4	Зөвлөмж	4	76,758.7	3	1,800.0	75.0
<b>Нийт дүн</b>		<b>5</b>	<b>76,877.2</b>	<b>4</b>	<b>1,918.5</b>	<b>87.5</b>

*/сая төгрөгөөр/*

Өмнөх оны аудитаар өгсөн 2 жил ба түүнээс дээш жилийн насжилттай авлагыг барагдуулах 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, биелэлт 87.5 хувийн биелэлттэй байна.

Олон жил болсон нажилт өндөртэй авлагуудыг барагдуулах талаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй тул дараагийн шийдлийг сонгож, албан шаардлага хүргүүлээ.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар дараах асуулуудад горим, сорилхэрэгжүүлэх шаарлагатай. Үүнд:

- ЭМДС-аас олгогдож байгаа тусламж үйлчилгээний нэхэмжлэхийн дүн, олгохоор тооцсон дүн болон хасагдуулгын дүнг Health.gov.mn программын дүнтэй тулган шалгах;
- Нэр, хаяг тодорхойгүй иргэнд анхан шатны тусламж үзүүлсэн гэсэн тайлбартай регистрийн дугаар, овог, нэр тодорхойгүй нэхэмжлэхээр санхүүжилт олгож байгаа асуудалд баримтын шалгалт хийх;

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт буруу тусган илэрхийлсэн 9,877.4 сая төгрөгийн 4 алдаа<sup>1</sup> илэрснийг залруулсан.

Санхүүгийн асуудлаар нийт 442,147.6 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс зөрчлийг таслан зогсоох 7 албан шаардлага хүргүүлсэн.

Нийт 442,147.6 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

### 5.1 Харьяа байгууллагууд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 3 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэж, түүвэрт хамруулсан.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 9,877.4 сая төгрөгийн алдааг залруулж, 64.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлсэн.

### 5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч

Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн 442,082.9 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага өгсөн.

#### 5.2.1 Албан шаардлага

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны орлогын төлөвлөгөөг 2,464,319.6 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 2,299,523.0 сая төгрөг буюу 93.3 хувь төвлөрүүлж, төлөвлөгөөг 164,796.6 сая төгрөгөөр дутуу бүрдүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", мөн хуулийн 6.2.2 "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлогыг нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлэх талаар анхаарч ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага хүргүүлээ.

2. Эрүүл мэндийн даатгалын нэгдсэн цахим системийн тусламж үйлчилгээний өгөгдлийн мэдээллийг тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын газраас ирүүлсэн лавлагаа шатлалын эмнэлгийн мэдээлэлтэй тулган шалгахад 159 эмнэлгийн нэхэмжлэхийн дүн 1,156.6 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь санхүүжилт буруу олгогдох эрсдэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийн даатгалын нэгдсэн цахим системийн тусламж үйлчилгээний өгөгдлийн мэдээллийг, лавлагаа шатлалын эмнэлгийн мэдээлэлтэй тулган шалгаж, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага хүргүүлэх.

3. Он дамжсан олон жилийн насжилттай Капитал банкнаас авах 74,199.9 сая төгрөг, Үндэсний хөрөнгө оруулалтын банкнаас авах 2,113.5 сая төгрөг, "Хаппи веритас" ХХК-аас авах 876.7 сая төгрөг зэрэг нийт 27 аж ахуйн нэгжтэй холбоотой авлагыг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй, найдваргүй авлага үүсэх эрсдэлтэй хэвээр, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй. Энэ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т

<sup>1</sup> Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", мөн хуулийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Он дамжсан олон жилийн насжилттай авлагыг барагдуулах талаар төлөвлөгөөтэй, үе шаттай арга хэмжээ авах, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох, албан шаардлага хүргүүлэх.

4. ЭМДС-ийн орлогын эх үүсвэртэй уялдуулан эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрөл, төлбөрийн хэмжээг тогтоогоогүйгээс жилийн эцэст эм, эмнэлгийн байгууллагуудад 198,390.9 сая төгрөгийн өртэй байгаа нь сангийн үйл ажиллагаа доголдох эрсдэлтэй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.2.2."жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогын эх үүсвэртэй уялдуулан эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрөл, төлбөрийн хэмжээг тогтоох, эм, эмнэлгийн байгууллагуудад өгөх өрийг барагдуулах талаар системтэй, бодлогын арга хэмжээ авах, албан шаардлага хүргүүлэх.

5. Тайлант онд хувийн хэвшлийн 17 эмнэлгээс 149.0 сая төгрөгийн санхүүжилтийн авлага шинээр үүссэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", мөн хуулийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийн даатгалын сангаас хувийн хэвшлийн эмнэлгүүдэд гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгож, авлага үүсгэсэн зөрчлийг таслан зогсоох, албан шаардлага хүргүүлэх.

### 5.3 Түүвэрт хамрагдсан байгууллагын зөрчлийн талаар

#### 5.3.1 Албан шаардлага

1. ЭМТЕГ нь газрын даргын 2025 оны А/10 дугаар тушаалаар "Сагсан бөмбөг, волейболын сургалт зохион байгуулах"-аар ЦОХИЛТ БНАО ХХК-тай 2,930.0 мянган төгрөг, "Найзууд сагсан бөмбөг хөгжил" НҮТББ-тай 2025 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр 2025/13 дугаартай 4,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, төсвийг үрэлгэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх", 4.1.9-д "хариуцлагатай байх" гэж тус тус заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалт бус, үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

2. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь ажлын байр түрээслэхээр 57,760.2 мянган төгрөгийн шууд гэрээ байгуулсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ" мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.", 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан

зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэж тус тус заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шууд гэрээ байгуулж, харьцуулалтын аргаас зайлхийсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох, албан шаардлага хүргүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 12 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

*/сая төгрөгөөр/*

№	Байгууллагын нэрс	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Эрүүл мэндийн даатгалын сан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл	1	8.3	-	-	1	8.3	1	8.3	-	-	-	-
3	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	3	9,869.1	-	-	3	9,869.10	3	9,869.10	-	-	-	-
<b>Нийт дүн</b>		<b>4</b>	<b>9,877.4</b>	-	-	<b>4</b>	<b>9,877.4</b>	<b>4</b>	<b>9,877.4</b>	-	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэрс	Нийт зөрчил		Үүнээс												
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Эрүүл мэндийн даатгалын сан	5	442,082.9			5	442,082.9									
2	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл	1	57.8			1	57.8									
3	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	1	6.9			1	6.9									
<b>Нийт дүн</b>		<b>7</b>	<b>442,147.6</b>	-	-	<b>7</b>	<b>442,147.6</b>	-	-	-	-	-	-	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

*/сая төгрөгөөр/*

№	Байгууллагын нэрс	Нийт зөрчил		Үүнээс											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан тушаалтны тоо	Тоо
1	Эрүүл мэндийн даатгалын сан	4	57.8	-	-	-	-	4	57.8	-	-	-	-	-	-
2	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл		-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	1	53.5	-	-	-	-	1	53.5	-	-	-	-	-	
<b>Нийт дүн</b>		<b>5</b>	<b>111.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>5</b>	<b>111.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1406/А0111371

Улаанбаатар хот

САГ - 2026/32/НА - СТА - ТЕЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын эх үүсвэртэй уялдуулан эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрөл, төлбөрийн хэмжээг тогтоогоогүйгээс жилийн эцэст эрүүл мэндийн байгууллагуудад 198,390,906,485.72 /нэг зуун ерэн найман тэрбум, гурван зуун ерэн сая, есөн зуун зургаан мянга, дөрвөн зуун наян тав/ төгрөгийн өртэй байгаа нь сангийн үйл ажиллагаа доголдох эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.2.2-д "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Орлогын эх үүсвэртэй уялдуулан эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрөл, төлбөрийн хэмжээг тогтоох, эм, эмнэлгийн байгууллагуудад өгөх өрийг барагдуулах талаар системтэй, бодлогын арга хэмжээ авч зөрчлийг таслан зогсоох, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд бөгөөд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга /Э.Батшугар/-т даалгав.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

СМ  С.МАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1407/A0111371

Улаанбаатар хот

САГ-2026/32/НА - СТА-ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн даатгалын нэгдсэн цахим системийн тусламж үйлчилгээний өгөгдлийн мэдээллийг Тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын газраас ирүүлсэн лавлагаа шатлалын эмнэлгийн мэдээлэлтэй тулган шалгахад 159 эмнэлгийн нэхэмжлэхийн дүн 1,156,552,326.00 /нэг тэрбум нэг зуун тавин зургаан сая таван зуун тавин хоёр мянга гурван зуун хорин зургаа/ төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.7-д "эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэлд санхүүгийн хяналт тавих", Төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "Холбогдох байгууллага, албан тушаалтан төсвийн мэдээллийн тогтолцоонд үнэн зөв мэдээллийг цаг хугацаанд нь оруулах, мэдээллийн үндсэн баримтыг бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, хамгаалах үүрэгтэй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-д "эд хэрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрүүл мэндийн даатгалын нэгдсэн цахим системийн тусламж үйлчилгээний өгөгдлийн мэдээллийг, лавлагаа шатлалын эмнэлгийн мэдээлэлтэй тулган шалгаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд бөгөөд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга /Э.Батшугар/-т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

СМАГНАЙСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0424\SAG-41.Docx

1526182269



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1408/А0111371

Улаанбаатар хот

САГ - 2026/32/НА-СТА-ТЭЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны орлогын төлөвлөгөөг 2,464,319,515,400.00 /хоёр их наяд дөрвөн зуун жаран дөрвөн тэрбум гурван зуун арван есөн сая таван зуун арван таван мянга дөрвөн зуу/ төгрөгөөр баталснаас, гүйцэтгэлээр 2,299,523,021,932.00 /хоёр их наяд хоёр зуун ерэн есөн тэрбум таван зуун хорин гурван сая хорин нэгэн мянга есөн зуун гучин хоёр/ төгрөг буюу 93.3 хувь төвлөрүүлж, төлөвлөгөөг 164,796,493,468.00 /нэг зуун жаран дөрвөн тэрбум долоон зуун ерэн зургаан сая дөрвөн зуун ерэн гурван мянга дөрвөн зуун жаран найм/ төгрөгөөр дутуу бүрдүүлсэн байна.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлд "Эрүүл мэндийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлогыг төвлөрүүлнэ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн орлогыг нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлэх талаар анхаарч ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд бөгөөд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга /Э.Батшугар/-т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

  
С.МАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1409/А0111371

Улаанбаатар хот

САГ-2026/32/НА - СТА-ТЭЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Он дамжсан олон жилийн насжилттай 77,589,793,370.93 /далан долоон тэрбум таван зуун наян есөн сая долоон зуун ерэн гурван мянга гурван зуун дал/ төгрөгийн 27 аж ахуйн нэгжтэй холбоотой авлагыг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй, найдваргүй авлага үүсэх эрсдэлтэй хэвээр, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", мөн хуулийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол", 4.2.1.11-д "хууль тогтоомж, ээрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Он дамжсан олон жилийн насжилттай авлагыг барагдуулах талаар төлөвлөгөөтэй, үе шаттай арга хэмжээ аваагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд бөгөөд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга /Э.Батшугар/-т даалгав.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

СМАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1410/АОИ/1371

Улаанбаатар хот

САГ-2026/32/НА-СТА-ТЭЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд хувийн хэвшлийн 17 эмнэлэгтэй холбоотой 149,012,231.58 /нэг зуун дөчин есөн сая арван хоёр мянга хоёр зуун гучин нэг/ төгрөгийн санхүүжилтийн авлага шинээр үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", мөн хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрүүл мэндийн даатгалын сангаас хувийн хэвшлийн эмнэлгүүдэд гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгож, авлага үүсгэдэг зөрчлийг таслан зогсоох, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд бөгөөд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга /Э.Батшугар/-т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

С.МАГНАЙСҮРЭН